

Ивана Гролова
/Бүгд Найрамдах Чех улсаас Монгол улсад суугаа
онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд/

Үзэсгэлэнт
сүү амлэг





Дэмбэрэлийн Оюунномин. Айл гэрийн эзэгтэй, эмэгтэй хүн ба дипломатч байхын заагийг хэрхэн тогтоодог вэ?

Ивана Гроллова. Ямар ч төрлийн ажил хийдэг байсан хүн хувийн амьдралаа хийж байгаа ажлаасаа үргэлж тусад нь байлгах ёстой. Шударга байж, үргэлж үнэнийг хэлж, эргэн тойрныхон, хамт ажиллагсдынхаа хүсэл сонирхлыг бас бодолцдог байхыг би зарчмаа болгодог. Бүхэл бүтэн улс орноо өөр оронд төлөөлөн сууж байгаа учир улс орныхоо эрх ашгийн төлөө ажиллах ёстой бөгөөд сууж байгаа улс орныхоо орчинд ч зохицож ажилладаг. Хэрвээ хувь хүний үзэл бодолтой маань нийцэхгүй ямар

нэгэн зүйл гарвал ажлаасаа сайн дураараа чөлөөлөгдөх эрх бий. Миний ажил орлогын маань гол эх үүсвэр учир ийм шийдвэр гаргах нь хэцүү ч хүний амьдрал гэдэг угаасаа л ёс суртахууны сонголтууд шүү дээ. Үргэлж нэг юмны талаар гомдоллодог ч түүнийгээ зогсоох ямар ч ажил хийдэггүй хүмүүсийг би ойлгодоггүй.

Д.О. Таны хүүхэд насны хамгийн нандин дурсамж...?

И.Г. Миний хүүхэд нас тэр чигээрээ аз жаргалаар дүүрэн байсан. Эцэг эхийн хайр халамжаар өчүүхэн ч дутаагүй, сайн багш нартай, эрүүл чийрэг гээд бүх юм л бүрэн бүтэн. Тийм ч учраас хүүхэд насны минь ихэнх дурсамж сайхан байдаг. Одоо харин хүүхдүүддээ өөр шигээ дүүрэн, бүрэн бүтэн гэр бүлийн аз жаргалыг мэдрүүлэхийг хичээж байна. Мэдээж тэр цаг үеэс хойш би өөрчлөгдөж амьдралын туршлага суусан.

Д.О. Та шүтлэгтэй юу. Хэрэв шүтлэгтэй бол ямар үзэл таны хувьд амьдралын үнэн гэсэн хэмжүүр болдог бол?

И.Г. Би ямар нэгэн шашны үзлийг байнга дагаж явдаггүй. Жишээ нь, аливаа байгалийн гайхамшигийг би хүний мэдлэгийн хүч юм уу, байгалийн хүчтэй холбож тайлбарладаг. Европ хүн учраас мэдээж өөрийнхөө хүүхдүүдийг Христийн домог түүхүүдийг мэддэг байгаасай гэж хүсдэг. Учир нь манай орны ёс заншилтай салшгүй холбоотой юм. Түүнчлэн өөр өөр төрлийн соёл, ёс заншлуудыг ч судлуулдаг. Өвөг дээдсийнхээ хамгаалагч сүнснүүдийг хүндэлж, итгэж явдаг ч тэднийг яг ид шидийн мэт зүйл хийж чаддаг гэдэгт итгэдэггүй. Миний итгэж явдаг зарчим бол бүх шашны баримталдгаар хүнд муу юм хийхгүй байх, сайныг чадлын хэрээр хийх явдал юм. Ямар ч шашны урсгалд мөргөж залбирахдаа юу ч гэж хэлдэг байсан, бид өөрсдийн хувьд хамгийн үнэ цэнтэй, алдахад хамгийн их шаналж гашуудах зүйлсээ мэддэг. Сайн ба муугийн

дүрмийг зөрчсөн тохиолдолд там гэж яг л ийм байна гэсэн ойлголтыг өгдөг. Эрт орой нэгэн цагт бүх хүн л бурханы шүүлт дээр очно гэдэг маш энгийн зарчим.

Д.О. Монгол улсад суугаа гадны иргэний хувьд, мөн монгол хүнтэй ханилсан гадаад эмэгтэйн үүднээс энэ асуултад хариулаасай гэж хүсч байна. Монголын нийгэмд гарч байгаа өөрчлөлтийг та хэрхэн харж байна вэ?

И.Г. Монголчууд нүүдэлчин соёлоосоо хотын соёл руу шилжиж байна. Энэ нь нийгэмд шинэ сорил, даваануудыг авчирч байгаа. Эрх чөлөөтэй, том газар нутагт цөөн хэдээрээ суурьшиж сурсан хүмүүс дөрвөн хананд хавчуулагдан, бусадтай хамтран оршин тогтнох дүрэмд суралцах хэрэгтэй болсон. Энэ нь нийгмийг хэт их бухимдалтай болгоод байх шиг. Монголчууд хүчирхэг, амжилттай улс орон болохын тулд хамгийн түрүүнд хүн бүхэн доторх комплексоосоо ангижрах ёстой байх. Өөрийгөө гайхамшигтай нэгэн гэж магтан хашгирдаг хүн миний хувьд хэзээ ч гайхамшигтай санагддаггүй. Өөрийнхөө мэдэж байгаа зүйлийг баяжуулж, өөрөөсөө илүү мэддэг хүмүүсээс байнга суралцаж байх нь чухал. Жинхэнэ агуу сэтгэлтэй хүн тэнэг харагдахаасаа айдаггүй, ухаалаг, өөрийн хэр хэмжээнд сэтгэл хангалуун байдаг. Өөрийгөө хүндэлдэг хүн бусдыг хүндэлж чаддаг. Ямар нэгэн маргааны үед, эсвэл зам гарах гээд зогсож байхдаа ч хажуудах хүнээ хүндэлж байх нь сул тал биш, харин ч их хүч чадал юм шүү.

Д.О. Та өөрийгөө эрчүүдийн талаар хэр сайн мэддэг гэж боддог вэ?

И.Г. Заримдаа тэдний эмэгтэйчүүдийн талаарх мэдлэгээс ч багыг мэддэг шиг санагддаг. Нас 50 гарч яваа болохоор ажил амьдралын хүрээнд олон л янзын эрчүүдтэй таарч явсан. Зарим тохиолдолд тэдний гаргадаг зан араншин хоорондоо төсөөтэй ч би аливаа юмыг ангилж харилцах

дургүй учраас тэгээд л орхичихдог. Хэн ч төгс биш гэдгийг л би мэднэ. Тэгэхээр, ажил болон хувийн амьдралдаа байгаа эрчүүдийн эерэг талыг түрүүлж хараад, сөрөг талтай нь эвлэрэх, эсвэл тохирох арга барилаар хамтран оршин тогтнож сурах хэрэгтэй. Хэрвээ тэр дутагдалтай тал нь тэсвэрлэхэд бэрх, эсвэл таны аль нэг үзэл бодолтой зөрчилдөж байвал түүнийг орхих нь зөв сонголт. Би маш азтай хүн. Намайг хүрээлэн байдаг эрчүүдийн эерэг тал нь дутагдалтай талаасаа их учраас би ч тэднээс маш их зүйлийг сурч мэдэж, ойлгож авдаг.

Д.О. Таны гэр бүлийн хүн манай сэтгүүлд ярилцлага өгөхдөө “Эрэгтэй эмэгтэй хүмүүс угаасаа л ондоо хэлээр ярьдаг шүү дээ. Эрэгтэй хүний ярьж байгаагаас эмэгтэй хүн зөвхөн өөрт хэрэгтэй, ашигтайг л авдаг. Эрэгтэй нь ч адилхан...” хэмээсэн. Та үүнтэй санал нэг байна уу?

Эрх чөлөөтэй, том газар нутагт цөөн хэдээрээ суурьшиж сурсан хүмүүс дөрвөн хананд хавчуулагдан, бусадтай хамтран оршин тогтнох дүрэмд суралцах хэрэгтэй болсон. Энэ нь нийгмийг хэт их бухимдалтай болгоод байх шиг.

И.Г. Би түүний юу хэлэх гэснийг маш сайн ойлгож байна, заримтай нь ч санал нийлнэ. Гэхдээ энэ зөвхөн хүйсний асуудал биш байх. Үг бол зөвхөн тэмдэг. Үгний ард хүн болгон өөрийн сонсохыг хүссэн зүйлээ ойлгон үлддэг. Эрүүл, хүчтэй, эсвэл сайн хооллодог гэдэг үгийг эерэг байдлаар хэрэглэхэд өөрийгөө илүүдэл жинтэй гэж боддог хүн бол эерэг утгыг анзаарахгүйгээр, шүүмж гэж хүлээж авна. Тэгэхээр энэ бол эрэгтэй эмэгтэй гэсэн хоёр өөр зүйл биш, харин хүмүүсийн хоорондын ойлголцлын түвшин, тэдний өөр өөр төлөвтэй холбоотой. Уг нь би хэрхэн баян болох вэ,

эрчүүдийг хэрхэн өөртөө татах вэ гэсэн утгатай ном уншаад байдаггүй л дээ. Харин өөрийн зүгээс санал болгож чадах гурван ном байна. Нэг нь, хэрхэн сайн ярьж сурах вэ гэдэг ном. Энэ номоос би олон нийтийн дунд үг хэлэх, харилцан яриа өрнүүлэх аргыг сурсан. Харин хоёр дахь нь, өөртөө итгэх итгэлийг олж авах, нөгөө хүнээ дарамт шахалтанд оруулахгүйгээр санаагаа зөв ойлгуулах гэсэн агуулгатай ном. Уг номд азийн харилцааны соёлыг маш ихээр тусгасан шиг санагдсан. Зөвхөн ажил хэргийн харилцаанд ч бус, хувь хүний харилцаанд ч гэсэн сайн тусалж чадах ном. Гурав дахь нь, доктор Грэйгийн “Эрчүүд Марсаас, эмэгтэйчүүд Венүсээс ирсэн” гэдэг ном. Энэ номыг дуустал нь уншаагүй ч, миний нөхөр яагаад ажлаасаа тарж гэртээ ирээд хэдэн цагаар компьютер тоглоом тоглоод суудгийн учрыг өөрийн уншсан хэсгээс ойлгосон. Тэр надтай, хүүхдүүдтэйгээ хамт

өөрөөр харагдаж, илүү өөдрөг сэтгэлтэй болж, хүүхдүүдээ хараад баярлаж, тэдэндээ оройн хоолыг нь хийж өгөхдөө өөрөө ч түүнээсээ таашаал авч чаддаг болсон. Энэ нь, би эрэгтэй хүн шиг болсон гэсэн үг биш, харин хүйсийн ялгаанаас хамаарахгүйгээр надад ч бас өөрийн гэсэн цаг хугацаа хэрэгтэй болсон гэсэн үг юм.

Д.О. Маш жижигхэн зүйлээс ч гэсэн бид таашаал авдаг шүү дээ. Энэ нь эмэгтэй хүнд илүү хамааралтай болов уу. Жишээ нь, гоёл чимэглэл хараад нүд баясна. Энэ бүхэн эмэгтэй хүний өдөр тутмын зайлшгүй шаардлага мөн үү. Эмэгтэй хүний гоё сайхан харагдах нууц юунд байдаг бол?

Танд байж болох хамгийн сайхан гоёл бол таны инээмсэглэл, гэрэлтсэн нүд, биеэ авч яваа ихэмсэг байдал, ухаалаг цэвэрхэн яриа л юм. Хэрвээ эдгээр зүйлс танд байхгүй бол таны алтан бөгж, үнэтэй шиншилла дээл тэдгээр дутагдлыг тань тийм ч удаан нууж чадахгүй.

И.Г. Бидний амьдралын жижигхэн ч гэсэн хэсэг нь амьтны ертөнцийн нөхөн үржих зөнтэй холбоотой. Тийм ч учраас бидний харагдах байдлын жижигхэн хэсэг нь ч гэсэн бидний сексийн чиг хандлагатай холбогддог гэсэн үг. Харин үлдсэн хэсэг нь миний бодлоор хувь хүний ухааны цар хүрээг илэрхийлж байх ёстой. Цаг хугацаа, байгаа орчин нөхцөлдөө тааруулж хувцасладаг байх ёстой. Өвөл дулаан хувцас, ууланд уулын гутал, олон нийтийн арга хэмжээнд ганган дэгжин гоёл чимэглэл гэх мэт. Аялал зугаалганд өсгийтэй гуталтай яваа хүн маш тэнэг харагддаг. Тэр эмэгтэйн хувьд өсгийтэй гутал үргэлж өмсөх нь тухтай байдгийг үгүйсгэхгүй л дээ. Гэхдээ хувь хүний хувцаслалт олон нийтийн дунд тэднийг хүндэлж байгаагаа харуулах нэгэн хэрэглүүр болдог. Сайхан хувцас өмссөн,

гоё үнэртэй хүнтэй харилцахад хэнд ч гэсэн сайхан л байна шүү дээ. Мөн нийгэмд эзлэх байр сууриа харгалзан зарим зүйлд илүү мэдрэмжтэй хандаж байх ёстой болов уу. Хамт ажиллагсад, найз нөхдийнхөө дунд тэдний хэзээ ч авч чадахгүй тансаг хэрэглэлийг хэрэглэн гайхуулж, эргэн тойрныхоо хүмүүсийг эвгүй байдалд оруулах шаардлага байхгүй. Ажил хэрэгч эмэгтэй хүн хэзээ ч бусдын анхаарлыг хэт татах задгай энгэртэй цамц, богино даашинз, банзал ажил дээрээ өмсдөггүй. Тийм учраас л ажил дээрээ хэдий энгийн ч гэсэн гоёмсог чимэглэлээр хувцсандаа өнгө нэмж, өөрөө ч түүнээсээ

таашаал авч чаддаг байх ёстой. Хэрвээ гоёл чимэглэл зүүх дургүй бол заавал ч зүүх албагүй. Тэр өдөр уулзсан эрчүүд бол бараг л анзаарахгүй, харин эмэгтэйчүүд нэг бол шуналын харц унагаж, эсвэл өөлсөн үг л хэлнэ. Танд байж болох хамгийн сайхан гоёл бол таны инээмсэглэл, гэрэлтсэн нүд, биеэ авч яваа ихэмсэг байдал, ухаалаг цэвэрхэн яриа л юм. Хэрвээ эдгээр зүйлс танд байхгүй бол таны алтан бөгж, үнэтэй шиншилла дээл тэдгээр дутагдлыг тань тийм ч удаан нууж чадахгүй. Гэхдээ монгол бүсгүйчүүд маш цэвэрч, энгийн хэрнээ донжтой хувцаслах урлагт аль хэдийнэ суралцсан учраас энэ бүхэн нэг их асуудал болдоггүй байх.

Д.О. Ямар үед эмэгтэй хүн өөрийнхөө хүйсийн онцлогийг жинхэнээсээ мэдэрдэг бол?

И.Г. Дэлхий дээр байгаа бүсгүй хүн бүр л байгалийн бүтээл, зарим нэг нь бурханы бүтээл ч гэдэг. Хэрвээ тэр хүн амьдарч л байгаа эмэгтэй хүн л гэсэн үг шүү дээ. Ямар ч зан ааштай, харагдах байдалтай байлаа гээд тэр хүн эмэгтэй биш болчихгүй. Би бол байнга л эмэгтэй хүн гэдгээ мэдэрдэг. Ядарсан эмэгтэй, хайрлагдсан эмэгтэй, хаягдсан эмэгтэй гээд авч байгаа мэдрэмж бүрээсээ л эмэгтэй хүн гэдгээ мэдэрдэг. Ээж болоод бас нэг сайхан мэдрэмж авсан ч энэ нь зөвхөн эмэгтэй хүний бус, харин байгалийн амьтны зөн юм шиг ээ.

Д.О. Гэрлэлт таны хувьд яг юу вэ. Та гэрлэлтийн төлөө ямар нэгэн зүйлээ зольсон уу?

И.Г. Золио гэдэг энэ ойлголт надад огт таалагддаггүй. Гэрлэлт, хүүхдүүд гээд амьдралынхаа туршид туулсан бүх зүйл маань миний амьдралыг илүү баялаг болгосон уу гэхээс би юуг ч золиогүй. Эргэн тойрны хүмүүст тохиолдож буй хүнд хэцүү үйл явдлуудыг хараад өөрт байгаа зүйлдээ улам л баярлаж, хувь тавиландаа талархаж явдаг. Цаг зав муу учраас илүү их ном уншиж чадахгүй байгаа, цэцэг тарьж чадаагүй, бичихийг хүссэн кино зохиолоо бичиж чадаагүй гэх мэт асуудлууд бол зөвхөн миний хувь хүний зохион байгуулалт, өөрийгөө дайчлах хүч дутагдсанаас л гарч буй асуудал. Энэ бол ямар нэгэн зүйлийн төлөө төлсөн миний золиос биш.

Д.О. Эмэгтэй хүн яг ямар байвал эр хүний хүний анхаарлыг татаж, хүндэтгэлийг хүлээх бол?

И.Г. Бид заримдаа анхаарал татах, хүндэтгэл төрүүлэх хоёрыг хооронд нь андуурч ойлгоод байх шиг санагддаг. Эр хүний анхаарлыг татах нь нэг өөр зүйл, эмэгтэй хүн болгон л өөрийн гэсэн анхаарал татах зүйлтэй, арга барилтай бөгөөд түүнийх нь үр дүн ч түр хугацааных байдаг. Харин хүндэтгэл төрүүлэх бол огт өөр зүйл. Үүнд хүйсийн ялгаа нэг их нөлөөлөхгүй. Хүний хүндлэл хүлээхийн тулд тухайн



Гэрэл зургийг Н.Галбалрал

хүн өөрөө хүндлэл хүлээхүйц зан чанартай байх ёстой. Хамтран ажилладаг хүмүүс, өрсөлдөгчид, хөршүүд, дарга нараа хүндлэн харилцаж байж та өөрөө бусдын хүндлэлийг олж авна. Монголын нийгэмд өнөөдөр энэ маш ихээр дутагдаж байгаа нь анзаарагддаг. Хүндлэлийг өгч, хүндлэлийг олж авч чаддаг хувь хүмүүсийг бэлдэх нь маш чухал. Библид “Өөрт тань бусдаас ирээсэй гэж хүсэхгүй байгаа үйлдлээ бусдад битгий үзүүл” гэсэн байдаг. Хүний өмсөж зүүсэн эд хэрэглэл хэзээ ч өөрт наалдах хүндлэлийг авч чадахгүй. Би маш олон сонирхолтой хүнийг танина. Тэдний ихэнх нь надад бодисадва шиг амьдарч байх шиг санагддаг. Аймшигтай үнэтэй эд хэрэглэл хэрэглэхгүй ч надад үргэлж л үзэсгэлэнтэй харагддаг. Ихэнх эрчүүд эмэгтэй хүний өмсөж зүүснийг бараг анзаардаггүй байх гэж би боддог. Харин тэд тухайн эмэгтэй ярилцахад сонирхолтой эсэх, хамтран ажиллахад чухал хүн эсэх, эсвэл зүгээр л уулзаж байхад тааламжтай хүн эсэхэд л анхаарлаа хандуулдаг.

Д.О. Танд ямар нэгэн айдас бий юу?

И.Г. Хайртай хүмүүстээ дарамт, садаа болох вий л гэж айдаг. Түүнээс биш, миний эргэн тойронд нас нэмэх тусам гайхалтай сайхан болж буй найзууд маш олон бий. Хэзээ ч уулзсан хөгжилтэй, үзэсгэлэнтэй, маш их мэдлэгтэй, илүү ухаалаг болсоор байдаг. Би гурав дахь хүүхдээ 49-тэйдөө төрүүлсэн. Энэ нь азийн философиор бол долоон долоо дахь жил дуусч байгаа тул маш сайн жил гэсэн байдаг. Би энэ азийн ухааныг их зөв гэж боддог. Одоо бол надад миний хувцаслалт, бусдад хэрхэн харагдаж байгаа маань, тэд надад анхаарал хандуулж байгаа эсэх нь огт хамаагүй. Ядаж л ирэх 18 жилдээ хайртай хүмүүстээ хэрэгтэй гэдгээ мэддэг болохоор эрүүл чийрэг байх нь миний хувьд маш чухал болсон. Бас энэ хугацаандаа түр зуур ч болов уйдаахгүй байх маш сайн баталгаа надад бий...□